

Цагаачлал ба дүрвэгсэдийн байгууллагаас илгээсэн шийдвэр бичигт тус улсыг орхин гарахыг шаардсан болон албан хүчээр гаргах тушаал гаргасан тохиолдолд анхаарах зөвлөмж:

Оршин суух тухай хуулийн дагуу тайлбар (оршин суух тухай хууль)

Оршин суух тухай хуулийн § 60a -ын 2d дагуу заавар

Та өөрийн нутаг руу буцаж чадахгүй хүнд өвчнөөр өвчилсөн бол эмчийн аттест бичгээр үүнийгээ батлах ёстой. Та таныг хариуцсан, гадаадын хэргийг хариуцах газарт эмчийн бичгийг даруй авчирч мэдэгдэх үүрэгтэй. "Даруй" авчирч мэдэгдэх гэдэг нь эмчийн бичигт буй огноог анхаарах хэрэгтэйг илтгэнэ. Хэрэв эмчийн бичигт таны насанд хүрээгүй хүүхэд эх орон уруугаа буцаж чадахгүй өвчилснийг заасан бол та үүнийг мөн мэдэгдэх үүрэгтэй.

Энэ бичгийг үзүүлэхгүй эсвэл оройтож мэдэгдсэн тохиолдолд уг бичигт тогдоогдсон өвчнийг эх орон руу нь буцаах үйл ажиллагаанд харгалзан үзэхгүй болно. Та ба эсвэл таны насанд хүрээгүй хүүхэд өвчтэй гэдэг тайлбарыг буцаах үйл ажиллагаанд сонсож, харгалзахгүй болно. Эмчийн бичгийг даруй авчирч танилцуулсан боловч энэ нь хууль журмын дагуу шаардлагыг хангахгүй тохиолдолд мөн адил үйлчилнэ.

Хэрэв таныг хариуцсан, гадаадын хэргийг хариуцах газар эмчийн бичигт эргэлзээтэй байгаа бол эмчийн үзлэг буюу албан журмын эмчийн үзлэгээр оруулах шийдвэр гаргана. Энэ шийдвэрийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй тохиолдолд гадаадын хэргийг хариуцах газар нь буцаах үйл ажиллагаанд өвчнийг харгалзахгүй байх эрхтэй.

Оршин суух тухай хуулийн § 50 -ийн 4 дагуу заавар

Оршин суух тухай хуулийн § 50 -ийн 4 дагуу та таны хаяг өөрчлөгдөх бүрд, мөн гадаадын хэргийг хариуцах газрын харьяалтай нутаг дэвсгэрээс 3 өдрөөс илүү хугацаатайгаар гарах тохиолдолд гадаадын хэргийг хариуцах газарт үүнийг мэдэгдэх үүрэгтэй. Энэ үүргийг биелүүлээгүй тохиолдолд та эх орон руу нь буцаах зорилготой хорих газарт хоригдох эрсдэлтэй (оршин суух тухай хуулийн §62-ын 3-ын дугаар 2)